ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум,
7-р баг, Жинст 0, Утас/Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 249

танай _____ -ны № _____ -т

ЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА П.АВИРМЭД ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлт, шийдвэрийг хүргүүллээ.

Аудитаар өгсөн шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлж биелэлтийн ирүүлнэ үү.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

07030278

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/08/-НА-СТА-ТТЗ

Дарга,Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Цэцэгмаа

Утас: 99177546 Цахим хаяг: Tsetsegmaab@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ 2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/ 5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ 6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/ 8
1. Аудитын тайлан 9
3.1. Ерөнхий зүйл 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
3.4 Материаллаг байдал 10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга 10
3.5.1 Орлогын данс 12
3.5.2 Зардлын данс 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 13
3.8 Аудитын гол асуудал 13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 14
4. Аудитын илрүүлэлт 14
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 181

танай -ны № -т

ЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.АВИРМЭД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТУВШИНБАЯР

07000475

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	852,034.9	1,104,249.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	189,934.3	239,408.4
33	АВЛАГА	170,080.3	299,426.6
35	БАРАА МАТЕРИАЛ	460,296.4	529,205.7
36	НӨӨЦИЙН БАРАА	12,723.8	12,723.8
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	19,000.0	23,485.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,899,867.5	4,681,589.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,899,867.5	4,681,589.5
39200	Биет хөрөнгө	4,815,498.9	4,597,029.6
39300	Биет бус хөрөнгө	84,368.6	84,560.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,751,902.4	5,785,839.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,999.9	15,483.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,999.9	15,483.8
41300	Өглөг	10,999.9	15,483.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,740,902.5	5,770,355.2
51	Засгийн газрын хувь оролцоо	5,740,902.5	5,770,355.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,240,650.5	1,240,650.5
51200	Хуримтлагдсан үр дүн	3,701,287.2	3,730,739.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	798,964.8	798,964.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,751,902.4	5,785,839.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,725,485.10	2,668,081.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	55,067.40	92,481.30
110	Орлогын албан татвар	49,056.10	56,985.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	49,056.10	56,985.80
113	Хөрөнгийн албан татвар	1,080.00	21,626.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,931.30	13,869.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,926,091.40	525,535.40
120	Нийтлэг татварын бус орлого	2,926,091.40	517,515.70
122	Тусламжийн орлого	0	8,019.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,744,326.30	2,050,065.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,089,949.20	2,598,211.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,089,949.20	2,598,211.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,024,838.10	2,527,123.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,055,853.50	1,124,146.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,730.40	148,115.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	240,564.40	287,012.40
2104	Хангамж, бараа материалын зардал	145,722.20	122,838.10
2105	Норматив зардал	47,142.10	231,033.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,997.40	24,428.50
2107	Томилолт, зочны зардал	2,970.00	3,518.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118,047.80	90,561.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	278,810.40	495,469.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,111.00	71,088.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,635,535.90	69,870.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,741.80	32,442.40
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,617,794.20	37,427.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,874,935.6	2,420,635.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	55,067.4	92,481.3
110	Орлогын албан татвар	49,056.1	56,985.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	49,056.1	56,985.8
113	Хөрөнгийн албан татвар	1,080.0	21,626.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,931.3	13,869.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,410.5	5,164.5
1181	Газрын төлбөр	860.8	1,265.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	660.0	7,439.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	295,346.6	385,052.4
120	Нийтлэг татварын бус орлого	295,346.6	385,052.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,524,521.6	1,943,102.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,667,723.4	2,171,892.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,667,723.4	2,171,892.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,822,351.5	2,099,580.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,106,059.9	1,199,409.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,173.2	174,414.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	248,625.1	298,697.6
2104	Хангамж, бараа материалын зардал	208,648.8	194,456.5
2105	Норматив зардал	35,991.5	120,372.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,026.9	23,806.4
2107	Томилолт, зочны зардал	2,970.0	3,518.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,854.9	60,967.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,001.1	23,937.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	845,371.9	72,311.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	207,212.2	248,743.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	47,063.0	105,269.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,063.0	105,269.7
2200	Дотоод эх үүсвэрээр	47,063.0	105,269.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-47,063.0	-105,269.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-69,500.0	-94,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	69,500.0	94,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	90,649.2	49,474.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	99,285.1	189,934.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	189,934.3	239,408.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,123,108.3	0.0	3,123,108.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,123,108.3	0.0	3,123,108.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	2,617,794.2	0.0	2,617,794.2
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,740,902.5	0.0	5,740,902.5
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,740,902.5	0.0	5,740,902.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,974.9	0.0	-7,974.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,732,927.6	0.0	5,732,927.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	37,427.6	0.0	37,427.6
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,770,355.2	0.0	5,770,355.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,974,788.50	1,905,313.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,813,336.30	1,754,054.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,789,804.10	1,730,614.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,125,901.30	1,102,416.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,730.90	145,627.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	285,899.10	283,679.03
2104	Хангамж, бараа материалын зардал	78,564.10	74,699.45
2105	Норматив зардал	54,187.00	46,195.89
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,508.90	42,501.40
2107	Томилолт, зочны зардал	3,580.00	2,643.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,781.50	15,033.54
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,651.30	17,817.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,532.20	23,440.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,532.20	23,440.76
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,502.20	57,258.50
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	94,950.00	94,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,974,788.50	1,895,978.86
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,021,271.90	998,591.12
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	807,625.10	793,554.61
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,137.50	7,314.59
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	127,754.00	96,518.54
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		59,462.51
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		50,127.92

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	183,657.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,657.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,585.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,729.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,488.42
2104	Хангамж, бараа материалын зардал	17,941.84
2105	Норматив зардал	74,176.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,050.00
2107	Томилолт, зочны зардал	875
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,703.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,620.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,072.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,190.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	882
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	183,657.99
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	183,657.99
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.09
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.09

1. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/66 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь "Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангахад оршино" гэсэн эрхэм зорилго тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 2,014.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 40.3 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 2,598.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 51.9 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.5 хувиар буюу 33.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 189.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 239.4 сая төгрөг болж, 49.5 сая төгрөгөөр өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн 203.5 сая нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд үлдсэн 35.9 сая төгрөг нь арилжааны банк дахь ААТҮГ-ын харилцах дансанд байршиж байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 170.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 300.8 сая төгрөг болж, 130.7 сая төгрөгөөр өссөн. Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлага 0.6 сая төгрөгийн, зээлийн авлага 169.4 сая төгрөгийн, 04 квт шугамын өргөтгөл засварын ажлын буюу ОНХС-ийн 7.1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй холбоотой ЭМТ-ийн 118.1 сая төгрөгийн, цалингийн нөхөн олговортой холбоотой Засаг даргын тамгын газрын 2.0 сая төгрөгийн, татвартай холбоотой Суурин дулаан ААТҮГ-ын 0.3 сая төгрөгийн, халаалтын төлбөртэй холбоотой Суурин дулаан

ААТҮГ-ын 3.3 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Байгууллагаас авах авлага нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн эргэлтийн хөрөнгийн түргэн хөрвөх чадварыг бууруулж цаашид төлөгдөхгүй тохиолдолд үргүй зардал бий болох сөрөг үр дагавартай.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд Суурин дулаан ААТҮГ-ын ЭМТ-өөс авах 1.4 сая төгрөгийн авлагыг хоорондын тооцоогоор устгасан байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 460.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 529.2 сая төгрөг болж, 68.9 сая төгрөгөөр өссөн, нөөцийн барааны эхний үлдэгдэл 12.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12.7 сая төгрөг буюу өөрчлөлт ороогүй, борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 19.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 23.5 сая төгрөг болж 4.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материал тайлант оны эцэст 529.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 2 хувь буюу 12.7 сая төгрөг нь орон нутаг хөгжлийн сангаас бэлтгэсэн өвс тэжээлийн нөөц байна. Тайлант онд бараа материал 551.4 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүний 64 хувь буюу 352.1 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн бол 34 хувь буюу 190.2 сая төгрөгийн бараа материалыг хандиваар, 2 хувь буюу 9.1 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан бол 482.5 сая төгрөгийн бараа материал хасагдаж оны эцэст 541.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,108.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,009.2 сая төгрөг болж, 99.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 46.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 152.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар, 33.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, бусад хэлбэрээр 74.7 сая төгрөгийн хөрөнгө авснаар нийт 307.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 335.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 72.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн нийт 407.2 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөд 498.8 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан ба шилжүүлсэн болон акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл болох 379.9 сая төгрөгийг дансны хасалт хэсэгт тайлагнасан байна.

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 10.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 16.9 сая төгрөг болж, 6.0 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ЭМТ-ийн 13.4 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, СХС, болон ЭМТ-ийн 1.1 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг, Суурин дулаан ААТҮГ-ын 2.4 сая төгрөгийн НӨАТ-ын татварын өглөг бүртгэлтэй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд ЭМТ-ийн Суурин дулаан ААТҮГ-т өгөх 1.4 сая төгрөгийн өглөгийг хоорондын тооцоогоор устгасан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,740.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,770.3 сая төгрөг болж, 29.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөөр 7.9 сая төгрөгийн элэгдлийн зардлыг залруулж, хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 3,730.7 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 92.5 сая төгрөгийн татварын орлого, 385.0 сая төгрөгийн татварын бус орлого, 2,721.3 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,198.8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 2,598.2 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 32.4 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Жаргалан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын "Сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай" 01 дүгээр тогтоолд зааснаар Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 49.9 сая төгрөгийн татварын, 3.5 сая төгрөгийн татварын бус нийт 53.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 96.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 180 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс шууд бус орлого, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөр, торгуулийн орлого тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд дээд шатны төсөв захирагчдаа тус тус хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийг 1,974.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, соёл урлаг, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрт зориулан 1,974.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,813.3 сая төгрөгийг урсгал зардалд, 66.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 94.9 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,021.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 752.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 55.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 18.1 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 41.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжих, 127.7 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,905.3 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь урсгал зардлыг хэмнэж мөн нэгж байгууллагын төсвөөс 36.7 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл буюу хэмнэлтийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой.

Төсвийг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 183.6 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 8.5 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3.8 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 62.6 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.9 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 103.6 сая төгрөгийн орлогыг тайлагнан 0.9 сая төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн орлогыг урсгал зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 17 мэдээллээс 9 мэдээллийг хугацаанд нь 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 75.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангаар өгөгдсөн шийдвэрээс 32.6 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулаагүй байна. Энэ нь тус төвлөрүүлэн захирагчид нэгтгэгддэг нэгж байгууллагуудын татварын цахим системийн илүү төлөлттэй холбоотой бөгөөд энэ онд нэгж байгууллагын удирдлагад үүссэн зөрүүг арилгах албан шаардлага хүргүүлсэн тул нэгтгэсэн тайлангаар давхардуулан шийдвэр өгсөнгүй.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчдад нэгтгэгдэг нэгж байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

Өмнө онуудад хийгдсэн санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгөгдсөн шийдвэрээс Жаргалан сумын ОНХС-ийн 7.0 сая төгрөгийн төлбөрийн акт биелэгдээгүй үлдэгдэлтэй байна. Энэ асуудалтай холбоотойгоор аймгийн Цагдаагийн газарт хэрэг үүсэн шалгагдаж байгаа тул аудитаар ямар нэгэн шийдвэр өгсөнгүй.

Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитын шийдвэрийг хэрэгжилт, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 4 тусгай сангийн нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 төсөвт байгууллага, 1 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" 4, "Хязгаарлалттай" (сумын ЗДТГ) 1 дүгнэлт өгсөн байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан тусгай сан болон нэгж байгууллагуудад 133.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 58.6 сая төгрөгийн алдааг залруулж, 8.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 31.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 6 зөвлөмжийг хүргүүлж 34.3 сая төгрөгийг зөрчлийг ҮАГ-т уламжилсан байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:
Аудитаар нийт 21.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:
Аудитаар Жаргалан сумын төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд залруулга хийгээгүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:
Аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагад залруулга хийгээгүй болно.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:
Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг гаргахад шууд бус орлого 9.2 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.1 сая төгрөг, газрын төлбөр 0.6 сая төгрөг, торгуулийн орлого 0.2 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

Жаргалан сумын ИТХ

Татварын тодорхойлолтоор 0.3 сая төгрөгийн дутуу, 0.6 сая төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Жаргалан сумын Соёлын төв

Тайлант онд 10.1 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
Жаргалан сумын Төвлөрүүлэн захирагч		1	10.1					1	10.1		
Түүвэрт хамрагдсан байгууллага											
Соёлын төв		1						1			
ИТХ		2	0.9					2	0.9		
Дүн		**4**	**11.0**					**4**	**11.0**		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
Төсвийн төвлөрүүлэн захирагч										
Дүн										
Соёлын төв	1	10.1					1	10.1		
ИТХ										
Дүн	**1**	**10.1**					**1**	**10.1**		
Нийт дүн	**5**	**21.1**					**5**	**21.1**		

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар 01/182 Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга (Р.Мөнхбаяр), нягтлан бодогч (Ж.Отгонжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭРДЭНЭЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР Б.ЦЭЦЭГМАА

8217144139
ДЮА0060 0018301

[1] Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Утас:70484030

07042494

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25өдөр Дугаар 02/182 Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Татварын тодорхойлолтоор 329.7 мянган төгрөгийн дутуу, 631.5 мянган төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын тодорхойлолтын зөрүүг арилган тооцоо нийлж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга (Р.Мөнхбаяр), нягтлан бодогч (Ж.Отгонжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭРДЭНЭЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР Б.ЦЭЦЭГМАА

8217144139
ДЮА00[illegible]18301

[1] Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Утас:70484030

07042498

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар 03/182 Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жаргалан сумын Соёлын төвийн эрхлэгч (П.Нэргүй), нягтлан бодогч (Ш.Сүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ӨРДЭНЭЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР Б.ЦЭЦЭГМАА

8217144139
ДЮА0062 0018301

[1] Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Утас:70484030

07042501

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар 04/182 Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд 10,100.0 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлбөрийн баримтыг нөхөн шивүүлэн тооцоо нийлж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жаргалан сумын Соёлын төвийн эрхлэгч (П.Нэргүй), нягтлан бодогч (Ш.Сүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭРДЭНЭЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР Б.ЦЭЦЭГМАА

8217144139
ДЮА0060 0018301

[1] Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Утас:70484030

07343504

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 22 өдөр Дугаар 05/182 Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Жаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг гаргахад шууд бус орлого 9,200.4 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 110.0 мянган төгрөг, газрын төлбөр 585.6 мянган төгрөг, торгуулийн орлого 222.3 мянган төгрөгөөр тус тус тасарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жаргалан сумын Засаг дарга (П.Авирмэд), санхүүгийн албаны дарга (Г.Цэрэндорж) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ӨРДЭНЭЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР Б.ЦЭЦЭГМАА

8217144139
ДЮА0060 0018301

[1] Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Утас:70484030

07042505